

19. Аав аа, Өмнөд Африкт зовж шаналж буй хүмүүст таны өршөөл, сайхан сэтгэлийг мэдрэх болтугай. Тэдэнд урам зориг өгч, нөхцөл байдлаас нь илүү цаадхыг харж, танд үйлчлэх болтугай. (Дуу. 31:19)

20. Эзэн минь, Танзани дахь хосууд бие биенээ хайрлаж, Таны ариун сүнсээр удирдуулан ариун амьдралаар амьдрах болтугай. Гэр бүл салалтын түвшинг нэмэгдүүлж буй хүчирхийлэл, хортой харилцаа болон бусад хүчин зүйлсийг эдгээж өгөөч. (1 Петр 4:8)

21. Бурхан минь, Зимбабвегийн залуу охидыг биеэ үнэлэхээс зайлсхийхийн тулд тэдэнд ажлын ур чадварыг эзэмшүүлээсэй гэж бид залбирч байна. (1 Тес. 4:3-4)

22. Эзэн минь, Бурунди дахь эд хөрөнгө өвлөх эрхтэй эмэгтэйчүүдийг хамгаалаач. Гэр бүлийнхээ эрэгтэй гишүүдэд эд хөрөнгөө алдахгүй байхад анхаарч өгнө үү. (Сургаалт үгс 31:9)

23. TWR-н "Найдвар доторх Эмэгтэйчүүд" хөтөлбөр Этиоп-д үйлчилж байгаад баярлалаа. Энэ багт хүч чадал, нигүүлсэл, мэргэн ухаан өгөгдөх болтугай. (Сургаалт үгс 2:6)

24. Эзэн минь ээ, Малави дахь эмэгтэйчүүд, охидыг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас хамгаалахыг бид танд уриалж байна. (Исаиа 1:17)

25. Бурхан минь, биднийг ариусгаач. Бидний бодол санаа, үг, үйлдэл танд таалагдах болтугай. Бидний оюун бодлыг шинэчилж, биднийг өөрчлөөч. (Ром. 12:2)

26. Аав аа, бид Танзани дахь ядуу эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Гэр бүлээ тэжээхийн тул ажил хийж, шаардлагатай ур чадварыг эзэмших болтугай. (Дэд хууль 15:11)

27. Бурхан минь, бид Зимбабвегийн гэр бүлүүдийн амар амгалангийн төлөө залбирч байна, хүүхдүүдэд сөргөөр нөлөөлдөг харгис хэрцгий зан үйлийг зогсоохын төлөө залбирч байна. (Исаиа 60:18)

28. Эзэн минь, Этиопд дэлхийн хөгжлөөс үүдэн цэцэрлэгээс коллеж хүртэлх олон сурагчид суралцах боломжтой таатай орчин бүрдэнд бид Таныг магтъя. (Ном. 7:12)

29. Аав аа, Малави улсын удирдагчдад мэргэн ухаан, урам зориг, хүч чадлыг өгөөч, ингэснээр тэд энэ үндэстнийг сайн удирдаж чадах болно. (Иошуа 1:9)

30. Бурхан аав аа, Өмнөд Африкт ажилгүй байгаа эмэгтэйчүүдэд хэрэгцээгээ хангахын тулд орлого олох боломжтой бүтээлч ажлын арга замыг өгөөч. (2 Коринт 9:8)

31. Эзэн минь, таныг Зимбабвегийн багш нарын хэрэгцээг хангаж, багшлах хүсэл тэмүүллийг нь сэргээж, оюутнуудад туслах зүрх сэтгэлтэй байхын төлөө залбирч байна. (Дуу. 32:8)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Найдвартай
эмэгтэйчүүд

Сар бүр гаргадаг "Найдвартай эмэгтэйчүүд" залбирлын хуанлиг 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2023. 8.

Африк эмэгтэйчүүдийн төлөөх залбирал 2

Олон африк хүмүүс зөвхөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээдүтмаг, авч чадахгүй байдгаас гадна ядуурал, бичиг үсэг тайлагдаагүй байдал, хүнс тэжээлийн дутагдал, ажилгүйдэл, өвчнөөс болон зовж, шаналж байна. Африкт шашин болон соёлоос шалтгаалан эмэгтэйчүүдийн эрх, статус маш доогуур үнэлэгдэж байдаг. Гэр бүлийн дарамт, албадан эрт гэрлүүлэх зэргээс шалтгаалан охид эмэгтэйчүүд сургуульд суралцаж чадахгүй байна. Тэдний дунд эрт гэрлэлтийн тухай ойлголт өөрчлөгдөж, хорт зуршлууд арилах болтугай.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Та бол өнчин хүүхдүүдийн эцэг билээ, Эзэн минь. Гудамжинд өлсөж, орон гэргүй, тусламж гуйж байгаа хүүхдүүдэд Бурунди улсын Засгийн газар санаа тавьж, гэр оронтой болгож халамжлах болтугай. (Дуу. 81:3).

2. Аав аа, Этиоп дахь Христэд итгэгчдэд улс төрийн тэдний эсрэг буй үзэл бодлыг сүмд оруулахаас татгалзах хүч чадал болоод ялган ойлгох ухааныг өгөөч. Улс төрийн энэ үзэл суртал нь тэдний нийгмийн харилцаанд нөлөөлж, гишүүдийн итгэлийг сулруулж болзошгүй юм. (Кол. 2:8).

3. Эзэн минь, Кени улсад байгаа хүмүүст Найробигийн нэвтрүүлгийн хэсгээр "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг бэлтгэж, дахин цацагдахын тулд шаардлагатай байгаа хөрөнгийг босгох боломжийг олгооч. (Дуу. 34:10).

4. Бурхан минь, бид Малави дахь эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших боломжийг илүү олон эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байхын төлөө залбирч байна. Эмэгтэй хүн ур чадвар, мэдлэгээ хөгжүүлснээрээ тэдний гэр бүлийн амьдралын чанар улам илүү сайжрах болно. (Сургаалт үгс 1:7).

5. Аав аа, Өмнөд Африкийн удирдагчдад таны сайн мэдээний төлөө үйлчилж байхдаа таныг танихгүй хүмүүсийн зүрх сэтгэлд хүрэхийн тулд энэрэн нигүүлсэхүй, нинжин сэтгэлээр дүүрэн зүрх сэтгэлийг бий болгож өгөөч. (Дуулал 107:1).

6. Бурхан минь, бид "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгээр дамжуулан Христийг хүлээн зөвшөөрсөн Занзибар дахь лалын шашинтнуудын төлөө залбирч байна. Тэдний танд итгэх итгэлийг хүчирхэгжүүлээч. (Матай 5:11).

7. Эзэн минь, Зимбабвегийн олон залуусыг амиа хорлоход хүргэж буй муу сүнснүүдийг хөөж өгөөч. Тэднийг босгон байгуулж, чиглүүлэхийн тулд зөвлөхүүдийг бэлтгэж өгнө үү. (1 Иохан 4:4).

8. Аав аа, Бурундигийн амьдрах ямар ч хүсэлгүй маш ядуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг ажлын байраар хангаж, наад захын хэрэгцээгээ хангахад туслаач. (Дуу. 34:6).



9. Хангагч Бурхан минь ээ, Этиопын шоронд байгаа зовж шаналж буй эмэгтэйчүүдэд үйлчилж, тэдэнд туслахын тулд итгэгчдийг босгож, бэлтгэж өгөөч. (Евр. 13:1–3).

10. Эзэн минь ээ, гэр бүлийн болон ажил мэргэжлийн үүргээ тэнцвэржүүлэх шаардлагатай Кени дэх ганц бие эмэгтэйчүүдэд мэргэн ухаан, хүч чадал өгөөч. (Дуу. 28:7)

11. Өршөөнгүй Бурхан минь ээ, Малави дахь Фредди хар салхинаас үүдэн маш олон гэр бүл, ойр дотнын хүмүүсээ болон эд хөрөнгөө алдсан тул эдгээж, тайвшруулж өгөөч. (Иохан 14:27)

12. Эзэн минь, Өмнөд Африкийн зүүн хошууны эмэгтэйчүүд хоса хэл дээрх "Найдвар доторх Эмэгтэйчүүд" хөтөлбөрөөс суралцаж, оюун санаандаа мэдлэгийг олж авах болтугай. (Филиппой 1:9-10)

13. Бурхан минь, Танзани улсад эмэгтэйчүүдийн бие махбодын шийтгэдэг, бэлэг эрхтнийг зэрэмдэглэдэг, эрт гэрлүүлдэг зэрэг эмэгтэйчүүдэд хор хөнөөл учруулдаг соёлын зан үйлийг зогсоож өгнө үү. (Еф. 5:25)

14. Тэнгэрлэг Эцэг минь ээ, бид танаас Зимбабве улсыг Африкийн талхны сагс болгон сэргээж ерөөхийг хүсэж байна. (Нахум 2:2).

15. Эзэн минь, бид Бурунди дахь үл итгэгч нөхрүүдийн авралын төлөө залбирч байна. Үл итгэгч нөхөр, итгэгч эхнэрүүдийн хоорондох сүнслэг итгэл үнэмшил дэх эв нэгдэлгүй байдал нь тэдний харилцаанд зөрчилдөөн үүсгэж байна. (Үйлс 16:30–33)

16. Дайны улмаас гэр орноосоо нүүлгэн шилжүүлсэн Этиоп улсын Некемте хотын ард түмнийг хувцас хунар, хоол хүнсээр хангаж байгаа ашгийн бус байгууллагуудын төлөө Бурхан Таныг Магтаж байна. (Дуу. 40:1).

17. Аав аа, Кенийн эмэгтэйчүүд, охидыг жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн бэлгийн хүчирхийллээс хамгаалаарай. Эдгээр эмэгтэйчүүдэд хор хөнөөл учруулж болзошгүй хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчлөөч. (2 Тесалоник 3:3).

18. Малави эмэгтэйчүүд Бурханы тайтгарал, хүч чадлыг олж Бурханд итгэх итгэл нь улам илүү бэхжих болтугай. (Исаиа 41:10).